



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/323

Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээн авах ажлын
хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/536 дугаар захирамж, Налайх дүүргийн Засаг даргын “Үнэлгээний хороо байгуулах тухай” 2019 оны А/206 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Киа моторс Монгол” ХХК-тай байгуулсан “Налайх дүүргийн зам талбайн цэвэрлэгээ, хот тохижилтын машин, механизм /Багц-3 Давхар кабинтай бага оврын ачааны автомашин-1ш/ худалдан авах” НДХААА-2019/Б-07 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй хөрөнгийг хүлээн авах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Налайх дүүрэгт нийлүүлэгдэж буй “Давхар кабинтай бага оврын ачааны автомашин-1ш”-ыг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг /М.Энхболд/-т даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 19.....өдрийн 1/33 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	М.Энхболд	Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Эрдэнэбаяр	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Ц.Эрбол	Налайх Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер /зөвшилцсөнөөр/
	О.Уранчимэг	Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Батаа	Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн